БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ "ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо[5]	Хувийн жин
1	2	3		4	5	6
2	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт [3] (YXX)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн батлсан эсэх [4]		1	0	0
		Төрийн албын хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	0	0
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх {6}	0.5	0,5	50
			Соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал {7}	0.5	0,5	50
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал {8}	0.5	0	0
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал {9}	0.5	0	0
Хэсгийн оноо				4	1	
4	Томилох эрх бүхий албан тушаалтан ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх {10} (гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)		1	1	100
		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал {11}		1	1	100

		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал {12}	1	1	100
Хэсгийн оноо			3	3	
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал [13]	1	1	100
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] (Гомдол ирээгүй бол 1 оноо авна нийт ирүүлсэн өргөдөл гомдлын хувийн жингээр тооцно)	1	1	
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]	1	1	
Хэсгийн оноо			3	3	
Үнэлгээний хувь			10	7	70%

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН "ТАЙЛАНГИЙН МАЯГТ" [1]

Нэг. Товч танилцуулга
Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны ТНБД-ын 2024 оны А/48 тушаал, Дэд хорооны 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийн хүрээнд ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО байгуулагдан, дарга, нарийн бичиг, гишүүд сонгогдов. 2025 оны 08 дугаар сард тус хороо нь бүрэлдэхүүндээ нөхөн сонгууль явуулж, бүрэлдэхүүнээ шинэчлэв. Яамны Ёс зүйн дэд хороо нь 2025 онд 4 удаа хуралдаж, 17 өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэн, 2 албан хаагчийг үндэсний Ёс зүйн сургагч багшид тодорхойлон сургалтад хамруулсан, нийт 11 удаагийн сургалт зохион байгуулж, дээд шатны Ёс зүйн дэд хорооны хуралд 1 удаа биечлэн оролцсон. Мөн дээд шатны Ёс зүйн асуудал эрхэлсэн байгууллагын гарсан шийдвэр чиглэлийн дагуу харьяа 83 байгууллагын Томилох эрх бүхий албан тушаалтнуудад 3 удаагийн албан чиглэл хүргүүлэв. 2025 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны биелэлтийг, авч шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын бүртгэлийн хүснэгттэй хамт Ёс зүйн хороонд 2026 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 13/340 тоот бичгээр хүргүүлсэн. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам нь харьяа 3 салбар, 1 хүн амын бүлгийн хүрээнд 83 байгууллагатай.
Хоёр. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2-т заасан Төрийн албан хаагчид тавигдах ёс зүйн нийтлэг шаардлагын хүрээнд ирсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, тус хуулийн 13 дугаар зүйл Ёс зүйн дэд хорооны бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, 15 дугаар зүйлд заасны дагуу гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэж, 19 дүгээр зүйлд заасан мэдээ, тайланг хүргүүлж байна. 1. Ёс зүйн дэд хороо нь 2025 оны жилийн хугацаанд 17 өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэсэн. Ёс зүйн дэд хороо нь ирсэн өргөдөл гомдлын хүрээнд 4 удаа хуралдаж, 4 дүгнэлт гарч, холбогдох гомдол гаргагчдад 14 албан тоотоор хариу хүргүүлсэн байна. 2. "Ёс зүйн зөрчил, бүртгэл, хяналтын модулийн нэвтрэх мэдээлэл"-г 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр цахимаар ирүүлсэн. Ирсэн мэдээллийн дагуу цахим санд нэвтрэн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны гишүүдийн бүртгэл болон дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө, ирсэн гомдол, өргөдөл, шийдвэрлэлтийн явц, гарсан шийдвэр зэргийг тогтмол хөтлөн явуулж байна. 3. Яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь 2025 онд нийт 11 удаагийн зөвлөн чиглүүлэх, соён гэгээрүүлэх сургалтыг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хүрээнд зохион байгуулсан. 4. Ёс зүйн дэд хороонд ирсэн өргөдөл гомдлын хүрээнд Ёс зүйн хариуцлага хүлээлгэх эрх зүйн үр дагавар бүхий зөрчил, дүгнэлт гаргаагүй байна. 5. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны цахим сайтад Ёс зүйн дэд хорооны тухайн оны бүрэлдэхүүн, төлөвлөгөө, тайланг тухай бүр байршуулан ажиллаж байна. 6. Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны тайланг Ёс зүйн хороонд 2026 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 13/340 тоот бичгээр хүргүүлсэн.
2.1 Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт
Зорилго 1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг удирдамж зааврааар хангаж, зохион байгуулалтыг сайжруулна.

- 2025 онд яамны Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнээс 2 гишүүн ажлаас гарч, дарга тухайн яамны томилох эрх бүхий албан тушаалтныг түр орлон гүйцэтгэгчээр томилогдсон. Энэ нь ирсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэхэд ачаалал, хүндрэл үүсэх нөхцөлийг бүрдүүлж, байгууллагын албан хаагчдын ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээг хийх боломжгүй байдлыг бий болгов. Мөн яамны бүтцийн өөрчлөлт, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, нэршилд өөрчлөлт орж, нийт албан хаагчдын шинэ албан тушаалын нэршлийн сонсох ажиллагаа эцэслэн явагдахад хугацаа алдсан. Иймд байгууллагын албан хаагчдын ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээг батлагдсан аргачлалын дагуу 2026 оны 1 дүгээр улиралд хийхээр төлөвлөж байна.

Зорилго 2.Төрийн албанд ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээ, шударга байдлыг эрхэмлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлнэ.

- Харьяа байгууллагууд дахь Ёс зүйн дэд хороодод Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хүрээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, ёс зүйн суурь ойлголт, зарчим, энэ хүрээний хууль тогтоомжийн мөн чанарыг хэрхэн ойлгож хэрэглэх, иргэд болон байгууллагад хэрхэн нөлөөлөх талаар сургалт, арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлж байна. 2025 онд харьяа Ёс зүйн дэд хорооны хүрээнд 5 удаагийн сургалт орсон байна.
- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам нь харьяа 3 салбар, 1 хүн амын бүлгийн хүрээнд 83 байгууллагатай. 2025 онд 83 салбар байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны судалгаа шинэчлэн авч, дарга, нарийн бичгийн дарга нарын холбоо барих мэдээллийг авч, мэдээлэл солилцох групп үүсгэн, цаг үеийн шуурхай мэдээллийг хуваалцан ажиллаж байна.
- УИХ-ын Ёс зүй дэгийн байнгын хорооны 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн "Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 04 дүгээр тогоол, Ёс зүйн хорооны 2025 оны "Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт батлах тухай" 04 дүгээр тогоол гарсантай тус тус холбогдуулан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны ТНБД-ын 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 02/2442 тоот "Тогтоолын хэрэгжилтийг хангах тухай" бичгийг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны харьяа байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтнуудад хүргүүлэв.
- Ёс зүйн хорооноос шинээр батлагдсан гарсан 2025 оны 06,07,08 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны ТНБД-ын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 02/3126 "Тогтоолын хэрэгжилтийг хангах тухай" албан тоотыг Харьяа байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтнуудад хүргүүлсэн.
- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь 2025 оны 08 сард Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны ТНБД-ын А/110 тушаалаар Ёс зүйн дэд хорооны гишүүдийг нөхөн сонгож албажуулав. Мөн тус бүрэлдэхүүнээр хуралдаж, дэд хорооны даргыг сонгож, ТНБД-ын А/116 тушаалаар албажууллаа.
- Ёс зүйн хорооноос шинээр батлагдсан гарсан 2025 оны 09 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны ТНБД-ын 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 03/46 "Тайлан ирүүлэх тухай" албан тоотыг Харьяа байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтнуудад хүргүүлсэн.
- Ёс зүйн хорооноос 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр цахимаар зохион байгуулсан "Төрийн байгууллагуудын дэргэдэх Ёс зүйн дэд хороодыг чадавхжуулах сургалт"-д Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн болон харьяа байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны гишүүдийг хамруулан ажиллав.

- Ёс зүйн хорооны 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 1/23 тоот “Ёс зүйн сургагч багшийн сургалтад нэр дэвшүүлэх тухай” албан тоотын дагуу Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Ёс зүйн дэд хорооны гишүүдэд мэдээлэл хүргэн, гишүүн Э.Батхүлэг, Г.Өнөрхуяг нарын танилцуулга, эсэх, материалыг бүрдүүлэн Ёс зүйн дэд хорооны даргын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны 06/220 тоот албан бичгээр хариу хүргүүлэв. Энэ хүрээнд дээрх 2 алба хаагчид нь Ёс зүйн хороо болон Удирдлагын академиас зохион байгуулсан 32 цагийн сургалтад хамрагдан үндэсний сургагч багшийн эрх авсан.
- Монгол Улсын Засгийн газрын 100 хоногийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан хувь хүний соёл, ёс зүй, эерэг хандлага, элдэг харилцааг эрхэмлэхэд чиглэсэн “Эерэг хандлага-идэвхтэй залуучууд” нийгмийн нөлөөллийн аяныг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны А/347 дугаар тушаал болон ТНБД-ын 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр баталсан удирдамжийн дагуу зохион байгуулж, Үндэсний шигшээ багийн баг тамирчдад зориулан “Тамирчны ёс зүй, хувь хүний соёл, эерэг хандлага”-ын талаар яриа, болон “Спорт дахь миний амьдрал, Оюутан тамирчны амьдрал” уулзалт, ярилцлагыг МУБИС, ШУТИС, Үндэсний биеийн тамирын их сургууль, Мон-Алтиус дээд сургууль, Аварга дээд сургуулийн 500 гаруй оюутан, залуучуудыг хамруулан зохион байгууллаа.
- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны дэргэдэх төрийн албаны салбар зөвлөл, Ёс зүйн дэд хороо нь хамтран Биеийн тамир спортын улсын хороонд зөвлөн туслах, арга зүй өгөх зорилгоор 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр 14:00 цагаас ажиллав. Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын хэрэгжилтийг хэрхэн үр дүнтэй ханган, зохион байгуулах зөвлөмж, арга зүй өгч ажиллаа.
- 2025 оны 5 дугаар сарын 27-ны өдөр Монгол Үндэсний түүхийн музейн нийт албан хаагчдад "Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ", Ёс зүйн дэд хорооны гишүүдэд "Ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх нь" сургалтыг тус тус зохион байгуулсан. Тус байгууллагын 50 албан хаагч, Ёс зүйн дэд хорооны 5 гишүүн хамрагдсан
- 2025 оны 6 дугаар сарын 05-ны өдөр Монгол Улсын Үндэсний номын сангийн нийт албан хаагчдад "Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ", Ёс зүйн дэд хорооны гишүүдэд "Ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх нь" сургалтыг зохион байгуулсан. Тус байгууллагын 60 албан хаагч, Ёс зүйн дэд хорооны 5 гишүүн тус тус хамрагдсан
- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь Биеийн тамир спортын улсын хороонд зөвлөн туслах, арга зүй өгөх зорилгоор 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдөр 14:30 цагаас Дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга ажиллав
- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь Үндэсний номын сангийн албан хаагчдад зөвлөн туслах, арга зүй өгөх зорилгоор 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдөр 09:30 цагаас Дэд хорооны нарийн бичгийн дарга, үндэсний ёс зүйн сургагч багш н.Өнөрхуяг нар ажиллав
- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Ёс зүйн дэд хорооны гишүүн Э.Батхүлэг, П.Алдармөнх нар Үндэсний урлагийн их театрын Ёс зүйн дэд хорооны гишүүдэд “Ёс зүйн зөрчил хянан шийдвэрлэх тухай”, тус театрын удирдах албан тушаалтан болон захиргааны гишүүдэд “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Үндэсний урлагийн их театрын бэлтгэлийн зааланд сургалт зохион байгуулсан
- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг 2025 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр Өвөрхангай аймагт, 4 сарын 26-ны өдөр Орхон аймагт, 5 дугаар сарын 10-ны өдөр Дундговь аймагт, 5 дугаар сарын 25-ны өдөр Сэлэнгэ аймагт зохион байгуулсан. Зөвлөгөөний үеэр Ёс зүйн дэд хорооны дарга Б.Даваацэрэн нь Төрийн албан хаагчийн ёс зүй, манлайлал сэдвээр сургалт орж нийт 5 удаагийн сургалтаар 500 гаруй албан хаагчид хамрагдав

- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Ёс зүйн дэд хорооны гишүүн Л.Энх-Амгалан нь Өмнөговь, Хэнтий аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, Театр, музей, номын сангийн алба хаагчдад хянал шалгалтын чиглэлээр ажиллах үеэрээ "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, дүрэм журмын" хүрээнд арга зүйн зөвлөмж өгч ажиллав.Мөн Хэнтий аймгийн Музейн дэргэдэх Ёс зүйн дэд хороог байгуулж ажиллаа.

Зорилго 4.Ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэхэд иргэний нийгэм, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог хангана.

- 2025 онд төсвийн тодотголтой холбоотойгоор төлөвлөсөн ажил хэрэгжих боломжгүй нөхцөл бүрдсэн.

2.2 Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

1. Байгууллагын ёс зүйн дэд хороо байгуулах, нөхөн сонгох, урамшуулахад цаг тухай бүр дэмжиж шийдвэрийг хурдан шуурхай гаргаж байна.
2. Байгууллагын тухайн оны төлөвлөгөөнд Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг тусган, шаардлагатай төсвийг хуваарилан шийдвэрлэж байна.
3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг тасалдалгүй, хэвийн явуулах орчин нөхцөл, танхим, тоног төхөөрөмжөөр хангаж байна.

2.3 Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа

- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Ёс зүйн дэд хороо нь Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын 2.4-т зааснаар 91-ээс дээш албан хаагчтай тул 7 хүний бүрэлдэхүүнтэй Ёс зүйн дэд хороог байгуулан, ТНБД-ын тушаалаар албажуулсан.
- Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын 2.5-т заасны дагуу сонгогдсон гишүүдийн хуралдаанаар олонхын саналаар Ёс зүйн дэд хорооны даргаа сонгон мөн ТНБД-ын тушаалаар албажуулсан. Тус тушаал болон дарга, гишүүд, нарийн бичгийн даргын тайлан, оролцоог үндэслэн урамшуулал олгогдож байна.
- Ёс зүйн дэд хорооны дарга нь журмын 3.1-д заасны дагуу жил бүрийн Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хуралдааны хөтөлбөрийг батлан хэлэлцэх асуудлыг тогтоож, хурлыг удирдан явуулж байна. Мөн иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг хүлээн авч гишүүдэд хуваарилж байна.
- Гишүүд нь журмын 3.3-т заасан чиг үүргийг хэрэгжүүлж байна.
- Нарийн бичгийн дарга нь 3.4т заасан чиг үүргийн дагуу хурлын тов, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг боловсруулж, гишүүдийн боломжит цаг хугацаанд үндэслэн хуралдааны хөтөлбөрийг даргаар батлуулж, бэлтгэл хангаж байна. Хурлын тэмдэглэл хөтлөн, албажуулж байна. Тухайн жилийн нийт гомдол, мэдээллийг цахим санд бүртгэж, цахим архив үүсгэн, бусад байгууллагаас ирэх тодруулга, хүсэлтэд хариу төлөвлөн хүргүүлж байна. Ёс зүйн дэд хорооны тайлан мэдээ, дээд байгууллагаас албан бичгээр ирүүлсэн чиглэлийн биелэлтийг хуульд заасан хугацаанд болон тухай бүр тайлагнан ажиллаж байна. Мөн тухайн салбар, харьяа байгууллага дахь Ёс зүйн дэд хороодын мэдээлэл, судалгаа авч, цаг үеийн мэдээллийг хурдан шуурхай хүргэн ажиллаж байна. Тухайн жилийн нийт өргөдөл гомдлын хугацаанд бүртгэлийн маягт санаачлан нэвтрүүлж, гишүүд, даргыг мэдээллээр хангаж ажиллаж байна.
- Яамны Ёс зүйн дэд хороо нь 2025 онд 4 удаа хуралдаж, 17 өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэн. Эдгээр өргөдлийн 3 нь 1111 төвөөс, 14 нь бичгээр ирсэн. Гомдолд холбогдогч 18, үүнээс эрэгтэй 11, эмэгтэй 7, Төрийн захиргааны 12, төрийн үйлчилгээний 5, бусад 1 байна. Гомдолд холбогдогч 18 хүний 9 удирдах, 7 гүйцэтгэх, 2 туслах албан тушаалтнууд байна. Нийт 17 гомдлын хүрээнд 4 дүгнэлт гарч, 1 иргэн гомдлоо эргүүлэн авч, 10 хамаарах асуудлын бус тул албан бичгээр буцаасан байна.

- Ёс зүйн дэд хороо нь 2025 онд 11 удаагийн Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг танилцуулах, сурталчлах сургалт, арга хэмжээг зохион байгуулсан байна.	
Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
Харьяа байгууллагуудын хүрээнд сургалтууд зохион байгуулагдсанаар Ёс зүйн дэд хорооны ажиллах чиглэл, хэрэгцээ шаардлага, ялгааны талаарх ойлголт хандлага сайжирч байна. Ирсэн өргөдөл гомдлын дагуу Ёс зүйн дэд хороодын мэдлэг, чадвар, туршлага сайжирч байна.	- Ёс зүйн дэд хороодыг яамдын түвшинд танхимын сургалтаар чадавхжуулах шаардлагатай. - Яамдын Ёс зүйн дэд хороодын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомж, шийдвэрүүдийн хүрээнд практик дахь туршлага, сайжруулалтын саналууд, хууль хэрэглээний зөрүүг арилгах хэрэгтэй. - Олон чухал шийдвэр гардаг хэдий ч түүнийг хэрхэн ойлгож хэрэглэх, нэвтрүүлэх талаар сургалт хангалтгүй байна. - Нарийн бичгийн даргын ачаалал их бөгөөд үндсэн ажлын хажуугаар ажиллахад хүндрэлтэй.
Санал: Ёс зүйн дэд хороодын саналыг авах хэлэлцүүлэг зохион байгуулах хэрэгтэй. Хууль тогтоомж, дүрэм журам гарч байгаа хэдий ч практик хэрэглээний зөвлөмж, арга зүй, сургалт хангалтгүй байна. Мэдээллийн санг практик туршлагатай нийцүүлэн сайжруулах шаардлагатай.	

Шалгах хэсэг:

- Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх
- Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх
- Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх

БАТАЛГААЖУУЛАЛТ:
Томилох эрх бүхий албан тушаалтан:

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Б.БАТ-ЭРДЭНЭ

Ёс зүйн дэд хорооны дарга

САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН Ч.ЭНХ-АМГАЛАН

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН
АХЛАХ ШИНЖЭЭЧ Э.ХУЛАН

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМНЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

№	Байгууллагын нэр	Байгуулсан шийдвэрийн огноо, дугаар	Гишүүдийн тоо	Дэд хороогоор хэлэлцэн шийдвэрлэсэн гомдол, мэдээлэл /2024-2025/ оны байдлаар	ЁЗДХ дарга	ЁЗДХ нарийн бичиг
СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ						
1	Соёл, спор, аялал жуулчлал, залуучуудын яам	2024.11.06-А/48	7	30	Ч.Энх-Амгалан	Э.Хулан
ЗГХА, Соёл, урлагийн газар						
2	ЗГХА, Соёл, урлагийн газар	2025.05.12 А/21	3	0	Н.Цацрал-99184452	О.Ганболд-99049458
21 АЙМАГ						
3	Орхон аймгийн СУАЖЗГ	2025.02.17 А/05	3	0	Б.Алтаншагай -99261146	А.Алтанцэцэг -99558053
4	Хөвсгөл аймгийн СУАЖЗГ	2025.01.17 А/02	3	1	Х.Баасансүрэн 99771162	Б.Болорцэцэг 99893361
5	Баянхонгор аймгийн СУАЖЗГ	2024.01.22 А/03	3	2	Д.Монголжийбуу 88050955	А.Мөнхцэцэг 88720017
6	Баян-Өлгий аймгийн СУАЖЗГ	2024.02.13 А/06	3	1	Б.Досжан-99424642	Х.Нурбахыт 99174052
7	Говьсүмбэр аймгийн СУАЖЗГ	2025.02.20 А/03	3	0	Х.Баяржаргал -99034275	Б.Лхагвамаа-96690436
8	Ховд аймгийн СУАЖЗГ	2024.02.15 А/03	3	0	Б.Ариунзаяа-90000093	М.Кистаубай-99664427
9	Өмнөговь аймгийн СУАЖЗГ	2025.04.14 А/12	3	1	Э.Уганчимэг 88067506	А.Нарангарав 80342023
10	Архангай аймгийн СУАЖЗГ	2024.02.01 А/03	3	0	Х.Батболд-94040969	Д.Сарангэрэл-99307484
11	Хэнтий аймгийн СУАЖЗГ	2024.01.30 А/04	3	0	Ц.Туяасайхан-91801144	Г.Ган-Эрдэнэ-80013735
12	Өвөрхангай аймгийн СУАЖЗГ	2025.02.06 А/05	3	3	Б.Эрдэнэчимэг-88709686	А.Бурэндэлгэр-85538080
13	Завхан аймгийн СУАЖЗГ	2025.04.29 А/06	3	0	Э.Пагмаа 88914292	Ц.Оттонцэцэг 99366346
14	Дорнод аймгийн СУАЖЗГ	2024.02.08 А/04	3	0	Г.Одонзул 80800101	Ч.Должинсүрэн 86862040
15	Дорноговь аймгийн СУАЖЗГ	2025.03.11 А/10	3	0	Н.Энхболор 86034473	Т.Дөлгөөн 91353757
16	Сүхбаатар аймгийн СУАЖЗГ	2025.04.01 А/14	3	0	Н.Дариймаа 99224521	П.Ариунболд 99003579
17	Булган аймгийн СУАЖЗГ	2025.01.13 А/02	3	0	Б.Эрдэнэбаатар 99349008	Т.Янжинлхам 99348099
18	Сэлэнгэ аймгийн СУАЖЗГ	2025.04.10 А/10	3	0	Х.Батбаатар 99075123	Э.Нямсүрэн 99842703
19	Увс аймгийн СУАЖЗГ	2025.02.04 А/02	3	0	Ч.Баттулга 99459090	Ц.Оролзодмаа 99323790
20	Төв аймгийн СУАЖЗГ	2025.01.21 А/03	3	0	Б.Цэцэгбадам 86008201	С.Энхбулаг 88087426
21	Говь-Алтай аймгийн СУАЖЗГ	2025.12.08 А/27	3	0	М.Сарантуяа 99482848	Ц.Баасанжав 88158864
22	Дархан-Уул аймгийн СУАЖЗГ	2024.02.07 А/04	3	0	П.Цогцэцэг 99086040	Д.Ариунжаргал 99022867
23	Дундговь аймгийн СУАЖЗГ	байгуулаагүй				
НИЙСЛЭЛ						
24	Нийслэлийн Соёл, урлагийн газар	2024.03.27 А/15	3	0	Д.Мөнхчулуун	М.Мөнхдаваа 99128544
25	Нийслэлийн Аялал жуулчлалын газар	2023.10.02 А/45	3	0	Б.Цолмонгэрэл 99040945	Ц.Энхотгон 95270351
ЗГХА, Биеийн тамир, спортын улсын хороо						
26	ЗГХА, Биеийн тамир, спортын улсын хороо	2025.12.15 А/369	3	2	Д.Цэрэндулам 99260088	З.Мөнхзул 99238008
21 АЙМАГ						
27	Орхон аймгийн БТСГ	2025.11.06 Б/54	3	0	Д.Одгэрэл 99037039	Ч.Болдцэцэг 99364092
28	Хөвсгөл аймгийн БТСГ	2023.11.07 А/58	3	0	Ш.Пагамсүрэн 88010922	Г.Баярдэлгэр 99977745
29	Баянхонгор аймгийн БТСГ	2023.10.30 А/52	5	6	П.Янжмаа 88019421	Б.Мөнх-Эрдэнэ 89303797
30	Баян-Өлгий аймгийн БТСГ	2025.03.19 А/42	3	2	М.Еркебулан 99164121	Д.Бейбит 99416326
31	Говьсүмбэр аймгийн БТСГ	2024.02.14 А/11	3	0	М.Батдэлгэр-80811024	Л.Зоригтбаатар-95046611
32	Ховд аймгийн БТСГ	2024.03.15 А/15	3	0	Ц.Сэр-Од-99433772	М.Бадамцэцэг -95626221
33	Өмнөговь аймгийн БТСГ	2025.01.08 А/02	3	0	Б.Одсүрэн 94778323	С.Одончимэг 99883533
34	Архангай аймгийн БТСГ	2025.01.16 А/03	3	3	Г.Энх-Амгалан	Х.Оюунбат 94910122
35	Хэнтий аймгийн БТСГ	2024.05.17 А/98	3	0	Л.Баяраа 99640113	Г.Батчимэг 98112404
36	Өвөрхангай аймгийн БТСГ	2024.09.12 А/42	3	0	Г.Нямсүрэн 88288355	Ч.Бат-Эрдэнэ 89032932
37	Завхан аймгийн БТСГ	2024.12.26 А/82	3	0	Б.Гансүх-99887852	Т.Нэмэхбаяр 95595903
38	Дорнод аймгийн БТСГ	2024.05.08 А/31	3	0	Б.Ишчойжил-89277979	Б.Халиунаа 88570258
39	Дорноговь аймгийн БТСГ	2025.02.04 А/08	5	0	Ч.Оттончулуун 99540403	Э.Оюунсүрэн 96665959
40	Сүхбаатар аймгийн БТСГ	2025-03-14 А/26	5	1	М.Мөнхжаргал 96096960	С.Батцэцэг 99770244
41	Булган аймгийн БТСГ	2024-04-05 А/38	3	0	Г.Нарантуяа 99238074	Э.Хосбаяр 99322925
42	Сэлэнгэ аймгийн БТСГ	2025.04.03 А/14	5	1	Б. Баянбулаг 88198123	Э. Дэлгэрцэцэг 94616169
43	Увс аймгийн БТСГ	2024.01.24 А/07	5	2	Ж.Оюунпүрэв-94398800	Т.Өлзийхишиг-99225686
44	Төв аймгийн БТСГ	2025.03.26 А/18	3	1	Л.Хишигдэлгэр 88222479	Г.Энхжин 88252105
45	Говь-Алтай аймгийн БТСГ	2024.02.14 А/ 08	3	0	Б.Магнайбаяр 99231857	
46	Дархан-Уул аймгийн БТСГ	2024.07.03 А/30	3	0	Б.Ховор-Эрдэнэ 95757671	Ш.Сэлэнгэ 99281593
47	Дундговь аймгийн БТСГ	2025.01.25 А/02	3	0	Ж.Батсайхан 95117755	С.Өлзийсайхан 99814076
НИЙСЛЭЛ /ДҮҮРЭГ/						
48	Нийслэлийн БТСХ	2025.08.01 А/28.	3	0	Г.Бямбасайхан -90098082	Б.Оюунтуяа-88080053
49	Налайх дүүргийн Спортын хороо	2024.12.02. А/72	3	0	О.Энхбилгүүн - 91311232	Э.Хунтайж -96115266
50	Багануур дүүргийн БТСХ	2023. 6.19 А/13	3	0	Ж.Болдбаатар 99969642	Б.Оттонцэцэг 99934327
51	Багахангай дүүргийн БТСХ	2025.02.08 А/03	3	0	Д.Алтанхуяг 99913670	Г.Ганчимэг 99938883
52	Баянзүрх дүүргийн БТСХ	2023.11.10 А/69	3	0	Ю.Батсайхан-98119746	А.Аззаяа- 88068816
53	Чингэлтэй дүүргийн БТСХ	2025.01.02 А/01	5	7	Б.Мөнхбаяр 99048153	П.Оттончимэг 99632468
54	Сүхбаатар дүүргийн БТСХ	2025.04.07 А/21	3	0	Х.Идэр 89090009	Б.Батжаргал 99096597
55	Сонгинохайрхан дүүргийн БТСХ	2025.01.13 А/06	3	0	Д.Намжил 99155846	П.Булган 99016613
56	Хан-уул дүүргийн БТСХ	2024.11.04 А/41	3	0	Б.Уртахбаяр 94946161	А.Ариунзул 95021003
57	Баянгол дүүргийн БТСХ	2025.01.16. А/14	3	0	А.Намчинханд 99804070	Э.Уранбилэг 80303973
ХАРЬЯА ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА						
58	Соёлын өвийн үндэсний төв	2025.02.26 А/09	5	1	Ц.Баянмөнх 99154611	М.Оюунтулга 80334415
59	Монголын Үндэсний музейн	2025.12.05 А/181	5	1	Г.Хос-Эрдэнэ 90414741	П.Батцэцэг 86610066
60	Чингис хаан Үндэсний музейн	2024.02.19 А/26	7	8	Ч.Бямбадорж- 99230366	Золжаргал -94990088
61	Байгалийн түүхийн музейн	2024-09-02 А/92	5	2	Д.Алтангэрэл 89218282	Ж.Мягмарсүрэн 99409924

62	Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей	2024.6.24 А/58	3	0	Б.Оюунчимэг 96915566	Д.Гоомарал 99763717
63	Богд хааны ордон музей	2025.04.14 А/25	3	1	М.Номундарь 99144316	Б.Бадамсэд 99960147
64	Чойжин ламын сүм музей	2024.02.08 А/07	3	0	Х.Болор-Эрдэнэ 88037879	А.Мөнх-Эрдэнэ 90693993
65	Монголын Уран зургийн галерей	2024.08.13 А\53	3	1	Б.Мөнгөнчимэг 89896984	Б.Чимэдхорлоо 99778237
66	Монголын Театрын музей	2025.04.22 А/18	3	0	Н.Эрдэнэбат 99136001	Ж.Энхжаргал 88905979
67	"Хөшөө цайдам" музей	2024.5.29 А/07	3	0	ЭША.М.Шаравжамц 9966490	С.Оюунтунгалаг 99561885
68	"Хархорум" музей	2024.01.18 А/03	3	0	Б.Дэжидмаа 99145544	С.Навчаа 80014446
69	Монголын Улсын Үндэсний номын сан	2024.02.05 А/08	5	0	П.Энхээ 99889022	Д.Бадамсүрэн 89933369
70	Хүүхдийн төв номын сан	2024.06.20 А/23	3	0	С.Тунгалаг 96019188	А.Итгэл 99120382
71	Улсын Драмын эрдмийн театр	2014.03.05 А/14	7	5	Ч.Найдандорж 96660199	Т.Оюун-Ундрах 89030244
72	Үндэсний урлагийн их театр	2025.08.12 А/20	7	0	Г.Цэрэндулам 95550333	
73	Улсын филармони	2024.05.17 А/16	7	0	Г.Алтан-Од 88004849	Л.Болормаа 89995889
74	Дуурь бүжгийн Эрдмийн театр	2024.12.28 А/55	7	2	М.Даваадорж 90114042	Мөнгөнбагана 993990095
75	Улсын Хүүхэлдэйн театр	2024.09.18 А/33	5	0	Д.Батмөнх-99895195	Я.Өнөртуул 90810885
76	Хүүхэд, залуучуудын театр	2024.10.30 А/66	7	0	Утга зохиолын ажилтан, Урын сангийн эрхлэгч Н.Уранзаяа - 99067623	Зохион байгуулагч Н.Алгирмаа - 80115239
77	Монгол Алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргаа	2024.03.01 А/25	4	0	Х.Ербахыт-99426771	Д.Айсауле-99423461
78	Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа	2025.01.29 А/07 2025.08.18 А/34	3	0	Н.Гомбожав - 99914009	З.Чаминцэцэг -96018229
79	Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн хамгаалалтын захиргаа	2024.01.12 Б/02	3	0	Б.Уянга-99015246	Э.Урандэлгэр-99021009
80	Чингис хааны өв соёлын хүрээлэн	2025.02.10 А/09	5	0	Ц.Эгиймаа-91179155	Л.Лхагвасүрэн-95634191
81	Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн	2024.04. 9 А/02	3	0	М.Алтанцагай-88778785	Ж.Должинсүрэн-99055370
82	Кино урлагийн зөвлөлийн Ажлын алба	2025.01.31 А/08	3	0	Г.Цэрэнпагма-94020422	Б.Батчулуун-95585950
83	Байгалийн түүхийн музейн ашиглалтын өмнөх захиргаа	байгуулаагүй				

БАТЛАВ:
СОЁЛЫН ӨВИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА Б.ДАВААЦЭРЭН

АТА12932 6594204 9024070546

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	Төсөв /сая төгрөг/	Хугацаа	Хариуцах
Зорилт: Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангана				
1.1 Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах				
1.1.1	Үндэсний хөтөлбөрийн биелэлтийг Ёс зүйн хороонд хүргүүлэх	-	I-IV улирал	Гишүүд
1.2 Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах				
1.2.1	Харьяа байгууллагын Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөмж чиглэл хүргэх, гишүүдийг чадавхжуулах арга хэмжээ зохион байгуулах. ҮХ 2.1.1, ҮХ 2.1.5, ҮХ 2.2.2, ҮХ 3.1.7	10.0	I-IV улирал	Ёс зүйн дэд хорооны гишүүд
1.2.2	Яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийг чадавхжуулах сургалтыг Ёс зүйн хороотой хамтран хэрэгжүүлэх ҮХ 2.1.1, ҮХ 3.1.7	-	I улирал	Ёс зүйн дэд хорооны Дарга, Нарийн бичгийн дарга
1.2.3	Салбарын нийт албан хаагчдад чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг Ёс зүйн дэд хороод, иргэний нийгмийн байгууллагатай хамтран зохион байгуулах ҮХ 2.2.1, ҮХ 2.2.4, ҮХ 2.2.5, ҮХ 4.1.1, ҮХ 4.1.2, ҮХ 4.1.3	15.0	III улирал	Ёс зүйн дэд хорооны гишүүд
1.2.4	Шинээр ажилд орсон ажилтанд чиглүүлэх 8 цагийн сургалтын агуулга, хөтөлбөр боловсруулж,	10.0	I,II улирал	Ёс зүйн дэд хорооны Дарга, Гишүүд

	батлуулах, түгээн дэлгэрүүлэх хэрэгжилтийг хангах ҮХ 1.2.5, ҮХ 1.3.4 , ҮХ 2.1.2			
1.2.5	Шинэ албан хаагчдыг хүлээн авах чиглүүлэх сургалтыг Хүний нөөцийн асуудал эрхэлсэн нэгжтэй хамтран зохион байгуулах ҮХ 1.2.3, ҮХ 2.1.3	ТЗУГ	II, III улирал	ТЗУГ Ёс зүйн дэд хорооны гишүүд
1.2.6	Байгууллагын нийт албан хаагчдад ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалтыг 2 удаа зохион байгуулах	5.0	I-IV улирал	Ёс зүйн дэд хорооны гишүүд
1.3 Ёс зүйн дэд хороонд ирсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх				
1.3.1	Хуулиар харьяалуулсан төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг бүртгэх, хянан шалгаж, дүгнэлт гаргах, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх ҮХ 1.1.3	-	I-IV улирал	Ёс зүйн дэд хорооны гишүүд
1.4 Ёс зүйн дэд хорооны тайлан мэдээг холбогдох хууль, журамд нийцүүлэн хугацаанд нь гаргаж хүргүүлэх				
1.4.1	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны тайланг дараа оны 1 дүгээр сарын ажлын сүүлийн өдөрт багтаан Ёс зүйн хороонд хүргүүлэх	-	I улирал	Ёс зүйн дэд хорооны Нарийн бичгийн дарга
1.4.2	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбогдох тайлан, мэдээг улирал бүр Ёс зүйн хороонд хүргүүлэх	-	I-IV улирал	Ёс зүйн дэд хорооны Нарийн бичгийн дарга
1.5 Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээллэх журмын хэрэгжилтийг хангах				
1.5.1	Журмын 2.1 заасан бүртгэлийг тогтмол хөтлөх ҮХ 3.3.2, ҮХ 3.3.3	-	I-IV улирал	Ёс зүйн дэд хорооны Нарийн бичгийн дарга
1.5.2	Цахим санг хөтлөх чиглэлээр нарийн бичгийн даргыг чадавхжуулах сургалтад тогтмол хамруулах	-	I-IV улирал	Ёс зүйн дэд хорооны Дарга
1.5.3	Байгууллагын цахим хуудсанд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, шийдвэрлэлтийн талаар мэдээллийг тогтмол байршуулах ҮХ 3.3.1, ҮХ 3.3.3, ҮХ 4.3.4	-	I-IV улирал	Ёс зүйн дэд хорооны Нарийн бичгийн дарга
1.6 Ёс зүйн дэд хорооны хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх				

1.6.1	Дарга, гишүүд, нарийн бичгийн даргад холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу урамшуулал олгох ҮХ 3.1.2	ТЗУГ	I-IV улирал	ТЗУГ
1.6.2	Албан хаагчдын ёс зүй, зан төлөвийн судалгаа/үнэлгээ хийх	-	II-III улирал	Гишүүд
		40 сая		

---oOo---